



ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ХАГАС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН БИЧМЭЛ ТАЙЛАН

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагын дарга, сумын иргэдийн хурлын дарга, засаг дарга нарын сургалтанд оролцож газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чигэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээ, анхааран ажиллах зүйлсийн талаар мэдээлэл өгч санал солилцлоо.

Мөн аймгийн Засаг даргатай байгуулах гүйтэтгэлийн төлөвлөгөө баталгаажууллаа.



2. 2022 онд газрын даамлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамж, арга зүйн зөвөлгөө өгөх сургалтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран 3 өдрийн хугацаанд зохион байгууллаа. Уг сургалтаар нь дараах зорилго, агуулга, сэдэвтэй байлаа.

- Цахим өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт- Кадастрын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Энх-Эрдэнэ, мэргэжилтэн Э.Энх-Эрдэнэ, Ц.Ламжав

- Сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах /Алдаа зөрчлүүд/- Газар зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Отгончимэг
- Хамгаалалтын бүс зурвас газрыг зурагжуулж, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системд оруулах- Газар зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн Г.Пүрэвжаргал
- Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээ- Хот байгуулалтын кадастрын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Баяржаргал, мэргэжилтэн Э.Ганчулуун
- Геопорталын хэрэглээ /мэдээлэл, технологийн болон Геодези, зураг зүйн чиглэлээр/- Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн дарга П.Нямдаваа, Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг
- Тоон гарын үсгийн хэрэглээ- Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн дарга П.Нямдаваа



3. Сумын газрын даамлууд болон мэргэжилтэнгүүд нартай 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллаа. Энэ жилийн гүйцэтгэлийн төлөвлөөгөөнд даамал бүр нэг буюу түүнээс дээш бүтээлч ажлыг нэмэлтээр оруулж аймгийн Засаг даргын үүрэг болгосон 15 заалт бүхий нэмэлтийг сум бүрийн онцлогт тохируулан байгуулснаараа онцлогтой байлаа.



3. “ЦАХИМ ШИЛЖИЛТ” Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгууллаа.

Egazar аппликейшн болон www.egazar.go.mn вейб сайтыг сурталчлах, цахим бүртгэлд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд “ЦАХИМ ШИЛЖИЛТ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Аймгийн Газрын Харилцаа, Барилга, Хот Байгуулалтын Газрын урд талбайд зохион байгууллаа.

Өдөрлөгөөр нийт 210 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч 305 ширхэг гарын авлага брошюрыг иргэдэд тарааж ажиллалаа.

- Цахим бүртгэлд нөхөн бүрдүүлэлт 54 иргэнд
- Газрын дуудлага худалдаа, газрын төлбөрийн мэдээллийг 31 иргэнд
- 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх 81 иргэнд

Egazar аппликейшн болон www.egazar.go.mn вейб сайт танилцуулга 50 гаруй иргэнд мэдээлэл өгч ажилласан байна.





4. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас санаачлан хэрэгжүүлж буй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах “Эргэх холбоо хамтын хүч” аяны хүрээнд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хамт олны зүгээс Товцог багийн иргэн М, Жаргалант багийн иргэн Н нарт тус тус сарын хэрэглээний хүнсний тусламж үзүүлж сайн үйлсын аянд нэгдлээ.



5. Улсын хэмжээнд газрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлт хийгдэж байгаа холбогдуулан дараах зар мэдээллийн цахим хуудас ашиглан зохион байгуулж 5400 гаруй нэгж талбарын мэдээллийн шинэчилж цахим болгоод байна.

Газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын газрын бүртгэл мэдээлэл нь газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим системд шилжсэнтэй холбогдуулан www.egazar.gov.mn газрын цахим системээр дамжуулж өөрийн газрын бүртгэл мэдээллийг шалгаж, баталгаажуулаарай.

Иргэн таны газар цахим системд ямар нэг бүртгэлгүй бол Аймгийн ГХБХБГ-ын 2 давхар Улиастай сумын газрын даамалд газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зурагтай биечлэн очиж бүртгүүлээрэй.



6. “ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ” сэдэвт сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгууллаа. “Төрийн албан хаагчийг богино хугацааны захиалгат сургалт”-д 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга нар, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж байна. Өнөөдрийн сургалтад:

- Төрийн албаны үнэт зүйлс, ба албан хаагчийн ёс зүй
- Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага
- Төрийн албаны шинэтгэл, эрх зүйн зохицуулалт
- Захиргааны шийдвэр хууль тогтоомжийн хэрэглээ сэдвээр Удирдлагын академийн доктор, дэд профессор, багш нар лекц, илтгэл тавилаа. Энэхүү сургалтын зорилго нь Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагын талаар нэгдсэн ойлголт мэдлэгтэй, Төрийн албан хаагчийн ёс зүй,



харилцаа, хандлага, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх арга зүй, төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн мэдлэгтэй боллоо

7. Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор батлагдсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **СУМ, СУУРИН ГАЗРЫН СУУРЬШЛЫН БҮС БУЮУ ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХИЛ ЗААГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ** ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдөр газрын даргаар удирдамжийг батлуулж 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хооронд хөдөөгийн **23** суманд удирдаамжинд заасан ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор батлагдсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ард иргэд, сумын удирдлагуудад танилцуулах;
- 2017 онд батлагдсан аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг танилцуулж, мэдээлэл хийх;
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах аргачлал зааврыг танилцуулах;
- Иргэд болон сумын удирдлагуудаас суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Сум, суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох;
- Хилийн цэсийн маргаантай сумдыг асуудлыг шийдвэрлэх;
- Газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, заавар зөвлөмж өгөх;
- Газрын кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг дуусгах;
- 2022 онд НҮБ-ийн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр хийгдэх Сумын нутаг дэсвгэрийн хөгжлийн төлөвлөгөө болосруулах сумдын мэргэжилтэн, удирдлагуудад арга зүйн зөвөлгөө өгч бэлтгэл ажлыг хангах талаар мэдээлэл өгөх.

Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө 2017-2033 он танилцуулж тухайн суманд хийгдэж арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгч санал солилцон ажиллалаа.

Мөн орон нутгийн удирдлагуудад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөө боловсруулахад анхаарах зүйлс, цахим

систем, хууль тогтоомж дагаж мөрдөх журам зааврын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч ажилласан.


Газар зохион байгуулалтын геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны А/209 тоот тушаалаар баталсан “Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар”-ын бүх сумдын удирдлагуудад танилцуулж тус журмыг ашиглах сум ххоронд үүссэн бодит бус маргааныг шийдвэрлэх талаар зөвлөмж өгсөн.

Мөн бодит маргаан байгаа эсэх талаар 1:100 000 масштабтай байр зүйн зургийг Ленд менежер программ хангамж хилийн цэстэй тулган маргаан үүссэн газруудын судалгаа, материалыг бэлтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.


2003, 2018 онд батлагдсан Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан Сум, суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг сумдын удирдлагууд танилцуулж өөрчлөх оруулах эсэх талаар саналыг авч Алдархаан, Ургамал, Цагаанчулуут, Идэр, Дөрвөлжин, Сонгино, Цэцэн-Уул, Сантмаргаз сумаас бусад нь өөрчлөлт оруулах саналтай байсан.

2003, 2018 онуудад батлагдсан төлөвлөгөөнд гол ай сав, усны хамгаалалтын бүсийг оруулсан өвөлжөө хаваржааны газартай давхцуулсан зэрэг зөрчлүүд байсныг арилган 15 сумын эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоолоо.


Ургамал сум




Цагаанчулуут сум




Эрдэнэхайрхан сум



Яруу сум




Цэцэн-Уул сум




Нөмрөг сум




Их-Уул сум




Тэлмэн сум




Баянтэс сум




Түдэвтэй сум




Тосонцэнгэл сум



Отгон сум




Шилүүстэй сум




Цагаанхайрхан сум




Сонгино сум




Завханмандал сум




Тэс сум




Асгат сум




Баянхайрхан сум




Дөрвөлжин



Идэр



Улиастай



ТАЙЛАН БИЧСЭН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ж.БУДСҮРЭН